



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/101

Хажуу шинэ үс

Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэр "Эхэн могой"-т байршилтай Чойёнгийн Батжаргал (ЗВ68061317)-ийн өвөлжөө, хаваржааны зориулалттай 5000 м.кв (0.5 га) газрыг Чойёнгийн Мөнхжаргал (ЗЕ87052215)-д зориулалтын дагуу шилжүүлэн 13 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг шинэчлэн олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Б. Хорол)-д зөвшөөрсүгэй.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч иргэнд үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2005 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн №25 дугаар захирамжийн хавсралтын 60 дэх хэсэг мөн газар эзэмших эрхийн 0000045484 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О. МӨНХ-АМГАЛАН

482201101